



Asian Shooting Academy

 **BROTHER  
MERCHANTS**

# 3 GUN БУУДЛАГЫН СПОРТЫН “5.11 CHALLENGE” ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

# 5.11

Бродер Мерчантс ХХК  
Азийн Буудлагын Академи  
Монголын Гурван Бууны Болон Төмөр Буудлагын Холбоо  
Ханан Ар Буудлагын Төв



# 1.Тэмцээний Тухай Мэдээлэл

## Тэмцээний Бүртгэл

Бүртгэлийн линк: <https://www.asianshooting.academy/>

Буудлага спортын тамирчин, тусгай албаны буудагчид оролцоно.

## Тэмцээний Бүртгэл Дуусах Хугацаа

06/10/2026 23:59

## Тэмцээний Огноо

Гар буу: 06/12/2026, 08:00 - 16:00

Гурван буу: 06/13/2026, 08:00 - 16:00

## Буудлагын Талбай

Тэмцээнийг Ханан ар буудлагын талбай дээр зохион байгуулна.

## Тэмцээний Хураамж

100,000 төгрөг

## Тэмцээний Төрөл

### 1. Гар буу/1 Gun

**Огноо: 06/12/2026**

Ангилал:

**Limited** - Ил харааны хэрэгсэлтэй гар буу  
**Зөвхөн эмэгтэй тамирчид оролцоно.**

Дасгалын тоо: 6

Сумны тоо: 150

Багийн дүн гарах эсэх: Үгүй

### 2. Гурван буу/3 Gun

**Огноо: 06/13/2026**

Ангилал:

**Limited** - Карбин, гар буу ил хараатай  
**Open** - Карбин, гар буу оптик, электрон хараатай (Аль нэг зэвсэг оптик, электрон хараатай бол энэ ангилалд орно.)

Дасгалын тоо: 6 (4 дасгал 2 Gun, 2 дасгал 3 Gun)

Сумны тоо: Гар буу 100, Карбин 80, Шотган 24

Багийн дүн гарах эсэх: Тийм

### 3. 5.11 Цагны буудлага

Ангилал:

**Limited** - Гар буу

Сумны тоо: 5

Steel challenge буудлагын 1 дасгалыг гүйцэтгэнэ. Аюулгүй ажиллагааны шаардлага хангасан болгон оролцож болно. Бүртгэл шаардлагагүй. Хэдэн ч удаа дасгал гүйцэтгэж болно. Хамгийн бага хугацаатай тамирчин 5.11 брэндийн цаг шагналд авна.

\*Баг: 4 тамирчнаас бүрдэнэ. Албаны буудагчид спорт хороо, клубийн нэрээр оролцож болно. Бүртгүүлэхдээ 1 ангилал, 1 нэрээр бүртгүүлнэ үү.

## 2.Шагнал

### Хувийн дүнгээр

**1-р байр** Батламж, медаль, ₮1,000,000 (5.11 дэлгүүрээс бүтээгдэхүүн авах эрхийн бичиг)

**2-р байр** Батламж, медаль, ₮600,000 (5.11 дэлгүүрээс бүтээгдэхүүн авах эрхийн бичиг)

**3-р байр** Батламж, медаль, ₮400,000 (5.11 дэлгүүрээс бүтээгдэхүүн авах эрхийн бичиг)

### Багийн дүнгээр

**1, 2, 3-р байр** Батламж

### Эмэгтэй хувийн дүнгээр (Зөвхөн гар бууны төрөл)

**1-р байр** Батламж, медаль, ₮1,000,000 (5.11 дэлгүүрээс бүтээгдэхүүн авах эрхийн бичиг)

**2-р байр** Батламж, медаль, ₮600,000 (5.11 дэлгүүрээс бүтээгдэхүүн авах эрхийн бичиг)

**3-р байр** Батламж, медаль, ₮400,000 (5.11 дэлгүүрээс бүтээгдэхүүн авах эрхийн бичиг)

## 3.Хуваарь

**Тэмцээний өдөр 1:** 06/12/2026 08:00 – 16:00

Нээлт 09:00 цагаас

Гар бууны эмэгтэй болон гадаад тамирчдын тэмцээн.

**Тэмцээний өдөр 2:** 06/13/2026 08:00 – 16:00

Нээлт 09:00 цагаас

3 Gun тэмцээн

**Тэмцээний хаалт, шагнал гардуулах ажиллагаа:** 06/14/2026 20:00 – 21:00

## 4.Холбоо Барих

### Тэмцээний зохион байгуулагчид:

МОНГОЛЫН ГУРВАН БУУНЫ БОЛОН ТӨМӨР БУУДЛАГЫН ХОЛБОО

Захирал. П.ЭРДЭНЭБИЛЭГ (Утас: 99117696)

БРОДЭР МЭРЧАНТС ХХК

Захирал. Б.ТАМИР (Утас: 99093493)

### Тэмцээний ерөнхий шүүгч:

М.БАЯРСАЙХАН (Утас: 94004774)

## 5.Санамж

### Гар буу, сум

1. Ган зүрхэвчтэй, шатаагч болон гэрэлтэгч сум (цэрэг, цагдаагийн) ашиглахыг хориглоно.
2. Аливаа сум хэрэгслийг Шүүгч аюултай гэж үзвэл тэмцээнд ашиглахыг зөвшөөрөхгүй.
3. Гар бууг суганд зүүхийг хориглоно.
4. Иргэний болон спортын буудагч нар гар бууг зөвхөн ташаанд зүүнэ.
5. Гар бууны гэр бүс нь өмдний 3-с доошгүй гогцоонд найдвартай бэхлэгдсэн байна.
6. Гэрт хийсэн гар бууны гол төмрийн чиглэл буудагчийн хөлөөс 1м-с ихгүй байна.

### Хувцас Хэрэглэл

1. Буудагчид спортын хувцас, чихэвч, нүдний шилтэй дасгал гүйцэтгэнэ.

### Аюулгүй Ажиллагааны Шаардлага:

1. Тэмцээнийг явуулахад аюулгүй ажиллагааны журмыг чанд сахина. Оролцогч тамирчид ба үзэгчдээс аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг биелүүлээгүй тохиолдолд тэмцээний талбайгаас гаргана.
  - Аливаа галт зэвсэгтэй үргэлж цэнэгтэй гэж болгоомжлон харьцана.
  - Галт зэвсэг буудлага үйлдэхээс бусад тохиолдолд үргэлж цэнэггүй байна.
  - Буудлага үйлдэхээс бусад үед гох дээр хуруу тавихгүй.
  - Зэвсгийн хошуу байнга аюулгүй зүгт, буудлагын үед бай руу чиглүүлнэ.
  - Буудлага үйлдэхдээ бай болон эргэн тойрноо байнга хянаж эрсдэлээс сэргийлнэ.
2. Буудлагын талбайд байгаа бүх буудагч нарын гар буу бууны гэрт магазин угсраагүй, цэнэггүй байдалтай байна.
3. Буудлагын талбайд байгаа хүн бүр хамгаалалтын нүдний шил, чихэвчийг байнга зүүнэ.

4. Шүүгчийн зөвшөөрөлгүйгээр бууг гэрнээс гаргах, магазин угсрахыг хориглоно.
5. Буутай харьцах бүх үйлдэл нь зөвхөн шүүгчийн командаар галын шугам дээр эсвэл “АЮУЛГҮЙН БҮС” дээр хийгдэнэ.
6. “АЮУЛГҮЙН БҮС” гэдэг нь тухайн буудлагын талбайд аюулгүй зүгт хуурай дасгал хийх, бууг задалж угсрах, тослох, засвар үйлчилгээ хийх зэрэг буудахаас бусад үйлдэл хийхийг зөвшөөрсөн газрыг хэлнэ.

### **“Аюулгүйн Бүс”-д Хориглох Зүйл**

1. Сум бүхий магазинд гар хүрэх, сум болон түүнтэй ижил төстэй загварын сум хэрэгслийг гарт барих, буунд сумтай магазин угсрахыг хориглоно.
2. Буудагч галын шугамаас бусад газарт бууг санамсаргүй унагаасан тохиолдолд тэмцээнээс хасагдах арга хэмжээ авагдахгүй ба бууг газраас өөрөө авахыг хориглоно.
3. Талбайн шүүгч унасан бууг газраас авахдаа оролцогч болон үзэгчдийг холдуулж, бууны амыг аюулгүй зүгт харуулан авна.
4. Магазиныг буудлагын талбайн аль ч хэсэгт сумлаж болно.

### **Тэмцээн Явагдах Журам, Оролцогчийг Бүртгэх**

1. Тэмцээнд оролцогч нь зарлагдсан хугацаанд багтан бүртгүүлнэ.
2. Бүртгэлд орсон буудагч нарыг бүлэг болгон хуваана.
3. Дасгал гүйцэтгэх буудагч нь зөвхөн талбайн шүүгчийн командаар бууг гаргаж цэнэглэнэ.
4. Тэмцээний төрөл бүрд эхний 3 буудагчийг шалгаруулна.
5. Дасгалыг гүйцэтгэх буудагч нь галын шугам дээр талбайн шүүгчийн “бууг цэнэглэж бэлдэнэ үү” командаар бууг гэр савнаас гарган цэнэглээд дасгалын заагдсан нөхцөлөөр бэлэн байдалд орно. Дараагийн “бэлэн үү” командын хариуд буудагч “Бэлэн” гэж хэлэх эсвэл толгой дохих, чимээгүй байдлаар дасгалыг гүйцэтгэхэд бэлэн гэдгийг илтгэнэ. Шүүгч “АНХААР” команд өгч 1-4 секундийн дараа дуут дохио дугарснаар дасгалыг эхлэх хугацаа явж, сүүлчийн буудалтаар хугацаа зогсоно. Дасгал гүйцэтгэсний дараа шүүгчийн “Хэрэв буудаж дууссан бол бууг шалгаж аюулгүй болгоод харуулна уу” командаар цэнэггүй болгосон бууг шүүгчид харуулан дараагийн “Хяналтын буудлага, БУУ ГЭРТ” командаар буудагч нь аюулгүй байдлыг сахин аюулгүй болгосон бууг гэр саванд хийнэ. Шүүгчийн “Байг шалга” командаар бай руу явна. Шүүгч нар байг шалгаж алдаа оноог тэмдэглэнэ.
6. Буудагч өөрийн оноо үнэн зөв бөглөгдсөн эсэхийг нягтлаад гарын үсгээр баталгаажуулна.
7. Үр дүнг тооцохдоо тухайн дасгалд авсан оноог гүйцэтгэсэн хугацаанд хуваана.

### **Тэмцээнээс Дараах Шалтгаанаар Хасна**

1. Дасгалыг гүйцэтгэх явцад буудлагын аюулгүйн өнцөг эвдсэн.
2. Дасгалыг гүйцэтгэх шилжилт хөдөлгөөний үед гох дээр хуруу тавьсан.
3. Дасгал гүйцэтгэх үед зүй бус үг хэллэг хэрэглэсэн буюу спортын бус байдлаар биеэ авч явсан.

4. Галын шугамаас гадна зэвсэгт магазиныг угсарсан.

**БАТЛАВ:**

МОНГОЛЫН ГУРВАН БУУНЫ БОЛОН ТӨМӨР БУУДЛАГЫН ХОЛБОО  
ЗАХИРАЛ П.ЭРДЭНЭБИЛЭГ

БРӨДЭР МЭРЧАНТС ХХК  
ЗАХИРАЛ

Б.ТАМИР